



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2023 оны 06 сарын 12 өдөр

Дугаар A/49

Улаанбаатар хот

Тооллогын комисс байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйл, 72 дугаар зүйлийн 1.4 дэх хэсэг, 73 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ :


1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 21-ний өдрийн дотор холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу зохион байгуулах үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Н.Ганболд	Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга
Гишүүн:	Д.Отгонтуяа	Ерөнхий нягтлан бодогч
	Б.Мөнхбаатар	Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
	Д.Дариймаа	Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
	Д.Будхүү	Мэдээлэл, технологийн албаны дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Янжинлхам	Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

2.Үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэл хөтлөлтийн холбогдох баримт бичгийг гаргаж өгөхийг нярав Ц..Эрдэнэцэцэгт даалгаж, тооллогын үр дүнг танилцуулахыг Комиссын дарга /Н.Ганболд/-д даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ



132013584